

**АЖЛЫН БАЙР/ АЛБАН ТУШААЛ/-НЫ
ТОДОРХОЙЛОЛТ**

А. ТАНИЛЦУУЛГА

1. Байгууллагын нэр: Дорноговь аймаг дахь МСҮТ	2. Нэгжийн нэр Сургалтын алба	
3. Ажлын байрны нэр : Нийгмийн түншлэл хариуцсан ажилтан	3.1 Албан тушаалын ангилал: Төрийн үйлчилгээний албан хаагч	3.2 Албан тушаалын зэрэглэл: ТҮ-7
4. Ажлын байрыг шууд харъяалан удирдах албан тушаалын нэр: Захирал	4.1 Албан тушаалын ангилал: Удирдах албан хаагч	4.2 Албан тушаалын зэрэглэл : ТҮМБ-6
5. Ажлын байрны шууд харъяалан удирдах албан тушаал	5.1 Албан тушаалын нэр:	5.2 Албан тушаал, эрхлэгчдийн тоо

Б. ЧИГ ҮҮРЭГ

1. Ажлын байрны зорилго	МБСБ-ын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд захирлыг мэргэжлийн, цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын дэмжлэгээр шуурхай хангах, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн Нийгмийн түншлэлийн байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, түншлэлийн хүрээнд гаргасан шийдвэрийг сургуулийн хэмжээнд хэрэгжүүлэх, зохион байгуулах, хамтарч ажиллах.
2. Ажлын байрны үндсэн зорилт	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт
Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг салбар, мэргэжлээр тодорхойлж, элсэлтэд тусгуулах, Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, ажил олгогчдод дэмжлэг үзүүлэх, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, МБСБ, ажил олгогчийн түншлэн ажиллах гэрээ, хэлэлцэл байгуулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг сурталчлах,	Хөдөлмөрийн бирж, хөдөлмөрийн хэлтсийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа, сургалтын байгууллагын хүчин чадалд үндэслэсэн элсэлтийг зохион байгуулсан байна. Сургалтын байгууллагатай хамтран ажилладаг үйлдвэрчний эвлэл мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж зэрэг сонирхогч этгээдийг түншлэлийн аливаа үйл ажиллагаанд татан оролцуулах, ажил олгогчдод сургалтын талаархи мэдээллийг бүрэн хүргүүлэх, салбарын төр, хувийн хэвшлийн түншлэлийн тэргүүн туршлагыг судалж нэвтрүүлсэн байна. Ажил олгогчидтой хамтран ажиллах гэрээ, дадлагын ажлын гэрээ байгуулж, элсэлт, дадлага, төгсөлт зэрэг сургалтын бүх шатанд ажил олгогчдын оролцоог хангаж, гэрээний биелэлтэд хяналт тавьж, үр дүнг олон нийтэд сурталчилсан байна.
МБСБ-ын төгсөгчдийн тандах судалгааг зохион байгуулах,	МБСБ-ын төгсөгчдийн ажил/хөдөлмөр/ эрхлэлтийн судалгааг нэгтгэж, Хөдөлмөрийн биржийн нэгдсэн

<p>хяналт тавих, үр дүнг сурталчлах,</p> <p>МБСБ-ын төгсөгчдийн тандах судалгааг зохион байгуулах, нэгтгэх, тайлагнах, удирдах ажилтнуудыг мэдээллээр хангах,</p> <p>Ажил олгогчидтой хамтран төгсөгчдийг ажлын байраар хангах ажлыг зохион байгуулж удирдлагаар хангах,</p> <p>Үйлдвэрлэлийн хүрээнд гарч буй шинэ технологи, бүтээлч санаачлагыг судалж, багш-инженер техникийн ажилтны харилцан туршлага судлах ажлыг зохион байгуулах,</p>	<p>МБСБ-ын төгсөгчдийн ажил/хөдөлмөр/ эрхлэлтийн судалгааг нэгтгэж, Хөдөлмөрийн биржийн нэгдсэн программд оруулж, тандах судалгааны талаархи мэдээллийг удирдах ажилтнуудад хүргүүлсэн байна.</p> <p>Салбарын болон бүс орон нутгийн ажил олгогчдийн ажлын байрны захиалгад тулгуурлан төгсөгчдийг ажлын байраар хангаж, төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь хэмжээг нэмэгдүүлсэн байна.</p> <p>Салбарын болон орон нутгийн түвшинд үйлдвэрлэлд нэвтэрч буй шинэ техник, тоног төхөөрөмжийн судалгаа гаргах, үйлдвэрлэлийн шинэ тоног төхөөрөмжийг сургалтад нэвтрүүлэх зорилгоор багш-инженер, техникийн ажилтаны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлнэ.</p>
<p>3.Ажлын байрны гол үйл ажиллагаа</p>	<p>3.1 Хугацаа, хувиар</p>
<p><u>1.Ажлын байрны нэгдүгээр үндсэн зорилтын хүрээнд:</u></p> <p>1.1. Хөдөлмөрийн судалгааны байгууллагатай хамтран орон нутгийн болон салбарын хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэй ажлын байр, мэргэжлийн судалгаа гаргуулан авах.</p> <p>1.2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, сургалтын байгууллагын хүчин чадал, багтаамжид нийцүүлэн суралцагч элсүүлэх мэргэжлийн чиглэл, элсэлтийн хяналтын тоог МБСҮЗ-ийн үйлдвэрлэл, үйлчилгээний болон орон нутгийн салбарын зөвлөлөөр хэлэлцүүлж, Хөдөлмөрийн яамны МБСБХЗГ-т хүргүүлнэ.</p> <p>1.3. ЕБС-ийн суралцагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллана.</p> <p>1.4. Сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх ажлыг зохион байгуулна.</p> <p><u>2. Ажлын байрны хоёрдугаар үндсэн зорилтын хүрээнд:</u></p> <p>2.1. Мэргэжил бүрээр ажил олгогчидтой хамтарсан зөвлөлдөх уулзалт зохион байгуулах,</p> <p>2.2. Салбарын хэмжээний түншлэлийн хамтын ажиллагааны тэргүүний туршлагыг судалж, нэвтрүүлэх,</p> <p>2.3. Ажил олгогчдын эрэлтэд нийцсэн сургалтын хэлбэрүүдийг эчнээ, орой, түр, гэрээт захиалгат гэх мэт туршин хэрэгжүүлэх, үр дүнг тооцох,</p> <p>2.4. Мэргэжлийн боловсрол сургалтын үйл ажиллагаанд ажил олгогчийн оролцоо, хариуцлагыг өндөржүүлж түншлэн ажилласан ажил олгогчдод хууль эрхзүйн хүрээнд дэмжлэг үзүүлэх, арга зүйн зөвлөлгөө өгөх,</p>	<p>20%</p> <p>15%</p>

<p>2.5. Ажил олгогчдын үйл ажиллагааны талаар үнэн бодит, зөв мэдээллийг өгч, олон нийтэд эерэг төсөөллийг бий болгоход хамтран ажиллах.</p>	
<p><u>3.Ажлын байрны гуравдугаар үндсэн зорилтын хүрээнд:</u></p>	
<p>3.1. МБСБ, ажил олгогчийн түншлэлийн хамтын ажиллагааны хоёр болон гурван талт харилцааг зохицуулах гэрээ, хэлцэл байгуулж хэрэгжилтэд хяналт тавих,</p>	15%
<p>3.2. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулахад мэргэжлийн холбоод, ажил олгогч, инженер-техникийн ажилчдыг татан оролцуулах,</p>	
<p>3.3. Компанийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэхэд хамтран ажиллах.</p>	
<p><u>4. Ажлын байрны дөрөвдүгээр үндсэн зорилтын хүрээнд:</u></p>	
<p>4.1. МБСБ-ын төгсөгчдийн тандах судалгааг төгссөний дараа 3, 6, 12 сарын дараа нэгтгэн Хөдөлмөрийн биржийн мэдээллийн санд оруулах,</p>	
<p>4.2. МБСБ-ын тандах судалгааны дүнг хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нь харьцуулан шинжилж орон нутгийн болон салбарын зөвлөл, удирдах ажилтануудыг мэдээллээр хангах.</p>	25%
<p><u>5. Ажлын байрны тавдугаар үндсэн зорилтын хүрээнд:</u></p>	
<p>5.1. Бүсийн болон орон нутгийн ажил олгогчидтой хамтран төгсөгчдийг мэргэжил тус бүрээр ажлын байранд зуучлах ажлыг хөдөлмөрийн байгууллагатай хамтран зохион байгуулах,</p>	15%
<p>5.2. Төгсөгчдийг ажлын байран дээр очсоны дараа ур чадварын үнэлгээ хийх.</p>	
<p><u>6. Ажлын байрны зургаадугаар үндсэн зорилтын хүрээнд:</u></p>	
<p>6.1. Түншлэн ажиллах ААНБ, компани хүрээнд бий болсон үйлдвэрлэлийн шинэ технологи, бүтээлч санаачлагыг судалж, сургалтад нэвтрүүлэх талаар хамтарч ажиллах,</p>	10%
<p>6.2. Шинэ техник тоног төхөөрөмжийг сургалтад нэвтрүүлэх зорилгоор багш-инженер техникийн ажилтны солилцож туршлага судлах, багш нарын мэргэшил дээшлүүлэх ажлыг зохион байгуулах,</p>	
<p>6.3. Ажил олгогчидтой хамтран үйлдвэрлэлд нэвтрүүлсэн шинэ тоног төхөөрөмжийг сургалтын орчинд нэвтрүүлэх.</p>	

В.ТАВИГДАХ ШААРДЛАГА.

1.Ажлын байранд			Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
			Боловсрол	Дээд боловсролын магистр болон түүнээс дээш зэрэгтэй	Бакалавр,
			Мэргэжил	Нийгмийн ажилтан, статистикч, багш мэргэжилтэй	Сэтгэл судлаач,
			Мэргэшил	“Хүний нөөцийн удирдлага”, “Төрийн удирдлага”,	“Өөрчлөлтийг манлайлах”, “Хүнийг манлайлах”,



				“Бизнес сэтгэлгээтэй байх”
			Туршлага	Мэргэжлээр 4–өөс доошгүй жил ажилласан байх, Үүнээс удирдах албанд 2-оос доошгүй жил ажилласан
			Ур чадвар	-Харьцааны өндөр ур чадвартай, -Хэрэглээний програмууд, интэрнетийн орчин, оффисийн цахим тоног төхөөрөмжүүд дээр ажиллах чадвартай, -Багаар ажиллах, -Удирдан зохион байгуулах, -Судалгаа боловсруулах, дүгнэлт гаргах, тайлагнах
		1.2 Тусгай шаардлага	Төрийн албан хаагчийн ёс зүйг чанд сахих, зарчимч албан болон хувийн нууцыг хадгалах, цэргийн алба хаасан байх, Төрийн албан хаагчийн шалгалтанд орсон байх	Илүү цагаар ажиллах, Ажлын ачаалал даах чадвартай, Зөв төлөвлөлтэй байх.

Г.ХУЧИН ЗҮЙЛС

1. Ажлын байрны харилцах субъект		
1.1 Байгууллагын дотор талд байгаа	1.2 Байгууллагын гадна талд байгаа	
Захирал Дэд захирал Сургалтын албаны дарга Багш нар	<ul style="list-style-type: none"> • МБСҮЗ-ийн Орон нутгийн салбарын зөвлөл, • Хөдөлмөрийн бирж, • Хөдөлмөрийн хэлтэс • Бусад Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд • Мэргэжлийн холбоод • Төрийн бус байгууллагууд • Ажил олгогч, аж ахуйн нэгжүүд • Бүсийн арга зүйн төвүүд • Иргэд 	
2. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага	Ажлын байрны тодорхойлолтонд заасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэн дотоод журмыг чандлан сахиж, үр дүнгийн гэрээнд заагдсан бүтээгдэхүүн нийлүүлэн захирлын өмнө хариуцлага хүлээнэ.	
Ажлын байрны нөөц, хэрэгсэл	3.1 Санхүүгийн	ТҮМБ-4 зэрэглэлээр Засгийн газрын хүчин төгөлдөр эрх зүйн актуудаар тогтоосон албан тушаалын цалин, хоол унааны нэмэгдэл бусад урамшуулалаас бүрдэнэ. Нийгмийн түншлэлийн хүрээнд уулзалт, зөвлөгөөн зохион байгуулахад гарах зардал,
	3.2 Материалын	Албан өрөөний тавилга, бичиг хэргийн болон компьютерийн техник хэрэгсэл,
	3.3 Хүний	Албаны нийт орон тооны хүрээнд ажиллах 3-4 ажилтан, багш г.м
	3.4 Бусад	Зөөврийн компьютер, скайнер, зургийн аппарат зарим шаардлагатай тохиолдолд прожектор
Ажлын байрны	4.1 Ердийн	Ажлын хэвийн нөхцөлд ажиллана.

НӨХЦӨЛ	НӨХЦӨЛ	
	4.2 Онцгой НӨХЦӨЛ	

Д.БАТАЛГААЖУУЛАЛТ

<p>Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан ажлын хэсэг буюу багийн ахлагч</p>	<p>Ажлын байрны тодорхойлолтыг баталсан эрх бүхий албан тушаалтан</p>
<p>Албан тушаалын нэр: МСҮТ-ийн сургалтын албаны дарга</p> <p>/Г.Оюунцэцэг / (Гарын үсэг) (Нэр)</p> <p>2017 оны 10 дугаар сарын 08-ны өдөр</p>	<p>Албан тушаалын нэр: МСҮТ-ийн захирал</p> <p>/Б.Адилбиш/ (Гарын үсэг) (Нэр)</p> <p>2017 оны 10 дугаар сарын 08-ны өдөр</p>